

Налайх дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл

Монгол Улсын эмнэлгийн ууган байгууллагын нэг нь Налайх дүүргийн эмнэлэг юм. Эмнэлгийн үүс ч хөгжсөн түүх нь Монголын анхны аж үйлдвэрийн ажилчид, гэр бүлийг үнэ төлбөргүй эмнэлгээр үйлчлэх шаардлагаар Дотоод Явдлын яамны хүн эмнэлгийн хэлтсийн даргын шийдвэрээр 1924 оны 08 дугаар сарын 25-анд байгуулагдсан тус эмнэлэг нь анх орос бага эмч, сувилагч, асрагч нарын гурван орон тоотойгоор ажиллаж эхэлсэн нь одоогийн эмнэлгийн тулгын чулуу болжээ.

ЭМН-ийн зорилго нь эмч, ажилтны ёс зүйн хэм хэмжээг чанд сахиулж, иргэдэд эрүүл мэндийн чанартай, хүргэж тэдний сэтгэл ханамжийг байнга өндөр хэмжээнд байлгахад оршино. Налайх дүүргийн ЭМН- нь нийт 314 орон тооны эмч, ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.

Эрүүл мэндийн нэгдлийн тусламж үйлчилгээний чанар, стандартын хэрэгжилтийг хангах, эмнэлгийн ажилтны ёс зүйн хандлагыг сайжруулах, эмч эмнэлгийн тусгай ур мэргэжилтний мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зэрэг зорилтуудыг тавин ажиллаж 2008 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж мөрдөн хэрэгжүүлнэ.

ЭМН-ийн даргын 2008 оны 01 дүгээр сарын 30-ний өдрийн 17 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар

Удирдлага хяналтын алба

Нийслэлийн эрүүл
мэндийн алба

Эмнэлгийн
Тусламжийн алба

1. Удирлагын алба

а. Захиргаа

б. Эмийн сан

в. Нэгдсэн гал тогоо

г. Засвар үйлчилгээний тасаг

2. Нийгмийн эрүүл мэндийн алба

а. Нийгмийн эрүүл мэндийн тасаг

б. Нэгдсэн лаборатори

в. Наркологи

г. Сургалт сурталчилгаа, судалгааны алба

3. Эмнэлгийн тусламжийн алба

а. Стационар

б. Шинжилгээний тасаг

в. Түргэн тусламж, авто гараж

г.Дотоод ариутгал, угаалга зэрэг бүтэц зохин байгуулалтыг шинэчлэгдсэн.